



**МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД**

17060 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын XIV байр,
Утас: 6226-3051, Факс: (976) 7004-3479

2013.10.31 № А/3381
танай _____-ны № _____-т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА Б.ГАРАМГАЙБААТАР ТАНАА

Б.Гарамгайбаатар
2013.11.07

“Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх,
түлш эрчим хүчний салбарын
өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим
хүчний үнэ тогтворжуулах” дэд
хөтөлбөрийн талаарх танилцуулга

Эрчим хүчний компаниудын санхүү, эдийн засгийн чадавхийг сайжруулах, салбарын өмнө тулгамдаж буй томоохон асуудлуудыг цаг алдалгүй шийдвэрлэх үүднээс сүүлийн жилүүдэд Улсын Их Хурал, Засгийн газраас чухал арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсээр байна.

Гэвч эрчим хүчний салбарын үйлдвэр, компаниудын техник тоног төхөөрөмж ихээхэн хуучирч ашиглалтын хугацаа дууссан, жил бүр цахилгаан дулааны хэрэглээ өсөн нэмэгдэж байгааг хангахад үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа болон цахилгаан, дулааны үнэ тариф бодит өртөгт хүрээгүй зэрэг гол хүчин зүйлүүдээс шалтгаалан санхүүгийн /чадавхи сул/ алдагдалтай ажиллаж байна.

Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч томоохон 25 компани 2012 онд нийт 372.6 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны орлого олж 438.9 тэрбум төгрөгийн зардал гарган үндсэн үйл ажиллагаанаас 66.3 тэрбум төгрөгийн, балансын дүнгээр 37.4 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан. Нийт 47.9 тэрбум төгрөгийн өр төлбөрийн 27 хувь нь нүүрсний, 35 хувь нь бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх, 24 хувь нь төслийн зээл, зээлийн хүүгийн, 6 хувь нь татвар шимтгэлийн, 2 хувь нь дотоодын банкны богино хугацаат зээлийн, 5 хувь нь импортын эрчим хүчний өр төлбөр тус тус эзэлж байна.

Эрчим хүчний компаниудын тарифын орлого нь үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд хүрэлцэхгүй байгаагаас алдагдал өмнөх жилүүдтэй харьцуулахад их хэмжээгээр нэмэгдлээ. Тухайлбал 2011 оны эцэст байсантай харьцуулахад 59 хувиар өссөн байна.

Улсын Их Хурлын 2010 оны 12 дугаар сарын 72 дугаар тогтоолоор эрчим хүчний салбарыг зах зээлийн харилцаанд үйл явцыг эрчимжүүлэхийг заасан боловч 2013 оны 07 дугаар сар гэхэд эрчим хүчний салбарт дараах хүчин зүйл нөлөөлж хөнгөлөлттэй зээл авах шаардлага гарсан юм.

“Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ тогтворжуулах” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөнгөлөлттэй зээл авах болсон шалтгаан:

008000344

1.Хэрэглэгчид, үйлдвэр аж ахуйн нэгж, байгууллагын эрчим хүчний үнэ тарифыг бодит өртгөөр тооцож нэмэгдүүлэх чиглэл барьж ажиллаж байсан боловч үнэ тарифыг нэмэхийг хязгаарласан.

2.Дулааны цахилгаан станцуудад эрчим хүч үйлдвэрлэх зориулалтаар нийлүүлж байгаа нүүрсний үнийг нэмээгүйгээс уурхайн уул, геологийн ажил хөрс хуулалт хоцорсон, техник тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа дууссан.

3..Өнгөрсөн жилийн / 2012-2013 оны / өвлийн оргил ачааллын үед төлөвлөж гэрээ хийсэн нүүрснээс 15300 тн. нүүрс илүү хэрэглэсэн нүүрсний өр төлбөр төлөгдөөгүй байсан. /Давсан шалтгаан нь эрчим хүчний хэрэглээ өсч, станцууд төлөвлөсөн хэмжээнээсээ давуулан цахилгаан эрчим хүч үйлдвэрлэсэнтэй холбоотой/

4.Жил бүр цахилгаан дулааны хэрэглээ өсөн нэмэгдэж байгааг хангахад үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын дутагдалтай байсан.

5.2013-2014 оны өвөлжилтийн бэлтгэл ажил цахилгаан дулааны цахилгаан станцуудын үндсэн болон туслах тоног төхөөрөмжийн засварын ажил санхүүгийн дутагдлаас болж дөнгөж 20 хувийн гүйцэтгэлтэй байсан юм.

Монгол Улсын эдийн засгийн суурь салбар болох эрчим хүчний салбарын санхүүгийн тогтвортой байдлыг хангаж үйл ажиллагааг хэвийн найдвартай явуулахад чиглэгдсэн шат дараалалтай арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаагийн нэг нь Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 186 дугаар тогтоол, 2013 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А-148,95 тоот Монголбанкны ерөнхийлөгч, Эрчим хүчний сайдын хамтарсан тушаал, дэд хөтөлбөр,Монголбанкны ерөнхийлөгчийн 2013 оны 08 дугаар сарын 07-ны А/163 дугаар тушаал, Монгол Улсын Төрийн өмчийн хорооны 2013 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 479 дүгээр тогтоол гаргасан юм.

Монголбанкнаас эрчим хүчний салбарт хэрэгжүүлж байгаа “Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ тогтворжуулах” дэд хөтөлбөрт эрчим хүчний салбарын 18 үйлдвэр, компаниуд 2 жилийн хугацаатай хамрагдаж 80 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч хэрэгжүүлж байна.

Энэхүү хөнгөлөлттэй зээлийн гол зорилго: Түлш, эрчим хүчний салбарын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, эдийн засгийн бусад салбар, ард иргэд, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн худалдан авах чадвар, өргөн хэрэглээний барааны үнийн хөөрөгдлийг бий болгох нөлөөлөл, инфляцийн түвшинг тогтвортой байлгах, эрчим хүч, дулааны үнэ тарифыг зах зээлийн үнэд ойртуулахад цаг хугацааны боломжийг олгох, 2013-2014 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангаж, эрчим хүчний тасралтгүй, найдвартай, ажиллагааг тогтвортой хангахад нүүрсний аюулгүйн нөөцийг бүрдүүлэх явдал юм.

“Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ тогтворжуулах” дэд хөтөлбөрт эрчим хүчний салбарын 18 тусгай зөвшөөрөл эзэмшигч цахилгаан, дулаан үйлдвэрлэгч, түгээгч үйлдвэр, компаниуд сонгосон дотоодын арилжааны банкуудын зээлийн хороогоор хянагдан өөрийн хөрөнгийг барьцаалан эхний ээлжинд 1 жил буюу 12 сарын хугацаанд эргэн төлөх чадвараас хамааран зээлийн гэрээг хийж хөтөлбөрт оролцож үлдсэн зээлийг хөтөлбөр 24 сар байна гэсний дагуу 2014-2015 оны төсвийн жилд авахаар төлөвлөн ажиллаж байна.

Хөтөлбөр эхний шатанд хэрэгжиж байгаа бөгөөд авбал зохих зээлээ бүрэн авч чадаагүй явдал нь өвөлжилтийн бэлтгэл, нүүрсний нөөц бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна.

Өнөөдрийн байдлаар 80.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг бүрэн аваагүй эрчим хүчний салбарын 8 үйлдвэр авч үлдсэн 10 үйлдвэр аж ахуйн нэгж Монголбанк болон арилжааны банкуудын зээлийн хороогоор материалыг хянан шалгаж байна.

Хөнгөлөлтэй зээл нь түлш, эрчим хүчний салбарын санхүүгийн чадавхийг тухайн үед дээшлүүлсэн боловч салбарын өрийг нэмэгдүүлж байгаа тул Улсын Их Хурлын 2010 оны 72 дугаар тогтоолоор заасны дагуу эрчим хүчний салбарыг зах зээлийн харилцаанд шилжүүлэн хэрэглэгчид, аж ахуйн нэгж байгууллагуудын хэрэглэсэн цахилгаан, дулааны үнэ тарифыг үе шаттайгаар нэмэгдүүлэн цахилгаан, дулаан, үнэ тариф бодит өртөгт хүргэх, өсөн нэмэгдэж байгаа цахилгаан, дулааны хэрэглээг хангахад эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчний чадлыг нэмэгдүүлэн шийдвэрлэх зайлшгүй шаардлага гарч ирж байгаа юм.

САЙД  М.СОНОМПИЛ

